Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны ...... дугаар сарын ....-ны өдрийн
.........дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙН ОНЦЛОГТ ТОХИРОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, СУРГАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургууль /цаашид "Сургалтын байгууллага" гэх/-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, суралцагч /цаашид суралцагч гэх/-ийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. "Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчин" гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил суралцахад шаардагдах нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг ойлгоно.

1.3. Сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулж болно.

1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасан үйлчилгээ нь энэ журамд хамаарахгүй.

## Хоёр. Сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнд тавих шаардлага

2.1. Сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд тохируулж сургалтын орчин бүрдүүлэхэд дор дурдсан стандарт шаардлагыг баримтална:

2.1.1. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин М666 6055:2009;

2.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага ММ8:6782:2019;

2.1.3. Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага МЫ8:6799:2019;

2.1.4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчин. Ерөнхий шаардлага МЫ8:6558:2015;

2.1.5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага МЫ8:6781:2019 стандарт.

2.2. Тохирох хэрэглэгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. суралцагчийн хэрэгцээнд нийцсэн, бусад суралцагчийн адил тэгш нөхцөлөөр сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг хангахад чиглэсэн;

2.2.2. суралцагчийн нас, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, хэрэглэгчийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой, ашиглахад хялбар байх;

2.2.3. мэдээлэл харилцааны технологи, тоног төхөөрөмж, программ хангамж, нэмэлт болон туслах үйлчилгээ нь суралцагчийн онцлог, хэрэгцээг хангахуйц байх.

## Гурав. Тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх

3.1. Бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцахад дэмжлэг болох зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3-т заасан тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй орчин бүрдүүлнэ.

3.2. Ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан тэдний хөгжлийг дэмжсэн тохируулгат хэрэглэгдэхүүнийг сонголттойгоор бүрдүүлсэн байна. Энэхүү сонголтыг хийхдээ шаардлагатай сургалтын тохируулгат хэрэглэгдэхүүний жишиг жагсаалтыг ашиглана. (Хавсралт 2)

3.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь дараагийн хичээлийн жилд хэрэглэгдэх сургалтын тохирох хэрэглэгдэхүүний хэрэгцээг жил бүрийн 1 дүгээр сард багтаан тодорхойлж, хичээл практикийн зардлаас зарцуулж шийдвэрлэнэ. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах зааврын” 2.6 дугаар заалтад дурдсан ялгаатай хэрэгцээтэй суралцагчид шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардлын хувь хэмжээнд үндэслэн санхүүжүүлнэ.

3.4. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 4.1.4-т заасан өмчийн бүх хэлбэрийн ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, хүүхдэд ногдох хувьсах зардлыг гурав дахин нэмэгдүүлж тооцох заалтыг баримтална. Суралцагчид ноогдох хичээл практикийн зардлыг мөн адил өсгөж тооцно.

3.5. Энэхүү журмын хавсралтад буй жагсаалтад багтсан тохирох хэрэглэгдэхүүний үнэ сургуулийн хичээл практикийн зардлаас хэтэрсэн тохиолдолд тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн судалгааг аймаг, нийслэлийн боловсролын газарт тухайн оны 2 дугаар сард багтаан хүргүүлэх;

3.6. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь энэхүү журмын 3.2-т заасан судалгааг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сард багтаан аймаг, нийслэлийн Засаг даргад болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын ерөнхий газарт тус тус хүргүүлнэ.

3.7. Энэхүү журмын 3.3-д заасан судалгаанд үндэслэн төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн хичээл практикийн зардлаас давсан үнэ бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах, нөхөн хангалт хийх ажлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

3.8. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

3.9. Ерөнхий боловсролын сургуульд ашиглах сурах бичгийн агуулгыг алдагдуулахгүйгээр хэлбэрийг өөрчлөх, шаардлагатай бол хялбаршуулан аудио, видео /хадмал орчуулгатай/, цахим хэлбэрт хувиргах, хэвлэн нийлүүлэхэд шаардагдах зардлыг

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

3.10. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэх зардлыг тухайн байгууллагын хичээл практикийн зардлаас шийдвэрлэнэ.

3.11. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд энэхүү журмын 3.1-д заасан орчин, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх хүрээнд дараах ажлыг зохион байгуулна:

3.11.1. сургалт /лекц, семинар, дадлага ажил/-ын үндсэн болон нэмэлт материал, сурах бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй, шаардлагатай тохиолдолд аудио, видео, цахим, брайл хэлбэрт шилжүүлэх, ашиглах зааврыг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх;

3.11.2. тухайн жилийн шинээр элсэгчдийн судалгаанд үндэслэн тохирох хэрэглэгдэхүүнийг баяжуулах, нөхөн хангалт хийх арга хэмжээг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулах.

3.12. Энэхүү журмын 3.8-д заасан тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухайн байгууллага хариуцна.

## Дөрөв. Суралцах үйлийг дэмжих

4.1. Бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тухайн орчинд дасан зохицох, суралцах үйлийг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. багш, ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээ, онцлогийг судлах, суралцагчийн онцлогт нийцсэн сургалтын арга зүйг төлөвлөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.2. суралцагчдын оролцоонд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгох, хүндлэх, нөхөрлөх, дэмжлэг үзүүлэх үзэл санааг хэвшүүлэх, тогтмол таниулан сурталчлах;

4.1.3. суралцагч болон эцэг эх, асран хамгаалагчдад тэгш хамран сургахтай холбоотой зөвлөгөө өгч, суралцагчийн сургалт, хөгжлийн явц, ахицыг тогтмол мэдээлж байх;

4.1.4. сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид өөрийгөө илэрхийлэх боломж бүрдүүлэх, олон нийтэд зориулан тэгш хамран сургахтай холбоотой сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

## Тав. Сургалтын хэрэглэгдэхүүний бүртгэл, ашиглалт

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн бүрдүүлсэн сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэж, ашиглалтыг дараах байдлаар зохицуулна:

5.1.1. цэцэрлэгийн арга зүйч сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг хариуцан ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нөхөн хангалтын захиалга хийх ажлыг хариуцан зохион байгуулна.

5.1.2. ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, хэрэгслийн ашиглалт, нөхөн хангалт хийх захиалгыг сургуулийн Дэмжлэгийн баг "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-д заасны дагуу зохион байгуулж, хариуцна.

5.1.3. их, дээд, сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд тоног төхөөрөмж, хэрэгслийг суралцагчид ашиглуулах болон хадгалалт, хамгаалалт, нөхөн хангалтын захиалга өгөх асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах боломж, эрхийг хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч хариуцан зохион байгуулна.

**Зургаа. Бусад**

6.1. Сургалтын байгууллага нь суралцагч болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгаа бэлтгэх, түгээх арга хэмжээ зохион байгуулахдаа тусгай хэрэгцээтэй хүний онцлогийг харгалзан тэдэнд тэгш, хүртээмжтэй байдлыг хангана.

6.2. Сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон сургалтын орчин бүрдүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага болон олон улсын байгууллага, иргэдийг оролцуулахад орон нутгийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлнэ.

оОо

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны ...... дугаар сарын ....-ны өдрийн .........дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Сургалтын тохируулгат хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт (Суралцагчийн тусгай хэрэгцээгээр )**

2.1. Аутизм, аутизмийн хүрээний эмгэгтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, орлуулах болон сайжруулах хэрэгсэл, тохируулгат сургалтын хэрэглэгдэхүүн

1. Зурган карт, ажлын хуваарь
2. Сургах багц тоглоом
   - Яриа бичигч
   - Яриа бичигч /7 хэсэгт/
   - Гелен хөлийн дэвсгэр
   - Ханын холбоочин
   - Массажны хэрэгсэл
   - Ярьдаг зургийн цомог
   - Мэдрэгчтэй тайвшруулагч
   - Том цаг таймер
   - Массажаар ороох
3. Гэрлэн сэрүүлэгтэй цаг
4. Трамполин
5. Суудлын зөөлөвч резин
6. Тайвшруулах буйдан
7. Тусгай сандал
8. Мэдрэхүйн тоглоомууд
9. Модон цар
10. Мешок, савлуур
11. Зууж хаздаг тоглоомууд
12. Хүндрүүлэгчтэй хантааз
13. Биеийн оймс
14. Бичгийн хэрэгсэл
15. Тэнцвэрийн тоглоом

1. Зурган карт, ажлын хуваарь





2. Сургалтын багц тоглоом



| № | Нэр | Зураг | | № | Нэр |
|---|---|---|---|---|---|
| **1** | Яриа бичигч /communicator/ |  |  | **2** | Яриа бичигч /7 хэсэгт/ |
| 3 | Гелэн хөлийн дэвсгэр |  |  | 4 | Ханын холбоочин |
| 5 | Массажны хэрэгсэл |  |  | 6 | Ярьдаг зургийн цомог |
| 7 | Мэдрэгчтэй тайвшруулагч |  |  | 8 | Том цаг таймер |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Массажаар ороох |  | | |

| № | Нэр | Зураг | № | Нэр |
|---|---|---|---|---|
| 3 | Гэрлэн сэрүүлэг тэй цаг |  | 4 | Трамполин |
| 5 | Суудлын зөөлөвч резин |   | 6 | Тайвшруулах буйдан |
| 7 | Тусгай сандал |  | 8 | Мэдрэхүйн тоглоомууд |
| 9 | Модон цар |  | 10 | Мешок савлуур |
| 11 | Зууж хаздаг тоглоому уд |  | 12 | Хүндрүүлэгчтэй хантааз |
| 13 | Биеийн оймс |  | 14 | Бичгийн хэрэгсэл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Тэнцвэрийн тоглоом |  | | |

2.2. Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэмжих төхөөрөмж, хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн

1. Дуут хөгжимт тоглоомууд
2. Хурууны мэдрэмж сайжруулах тоглоомууд
3. Гар, хөлийн мэдрэхүй хөгжүүлэх замууд
4. Брайль шатар, даам
5. Типоскоп – мөр заагч
6. Томруулдаг шил
7. Өнгөт, хуванцар, хатуу тууз
8. Том шугамтай дэвтэр
9. Хөдөлгөөнт чийдэн
10. Номын тавиур
11. Сурагчийн брайль самбар
12. Шивүүр
13. Брайль цаас
14. Брайль үсэг
15. Цаасгүйгээр бичиж, унших төхөөрөмж
16. Брайль бичгийн машин
17. Дэлгэц уншигч /Яриа хөрвүүлэгч/
18. Оптикийн тэмдэгт танигч программ хангамж
19. Уншдаг сканнер
20. Уншигч машин
21. Брайль үсгээр хэвлэгч
22. Хуурцаг
23. Брайль тэмдэглэлийн дэвтэр
24. Брайль дэлхийн газрын зураг
25. Milestone 312 Дэйзи /DAISY/ тоглуулагч
26. Booksense DS S50 Дэйзи тоглуулагч
27. Өнгө мэдрэгч
28. Гэрэл мэдрэгч
29. Ярьдаг тооны машин

| № | Нэр | Зураг | № | Нэр |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1** | Дуут хөгжимт тоглоомууд |   | **2** | Хурууны мэдрэмж сайжруулах тоглоомууд |
| 3 | Гар, хөлийн мэдрэхүй хөгжүүлэх замууд |   | 4 | Брайль шатар, даам |
| 5 | Мөр заагч /типоскоп/ |   | 6 | Томруулдаг шил |
| 7 | Өнгөт хуванцар, хатуу тууз |   | 8 | Том шугамтай дэвтэр |
| 9 | Хөдөлгөөнт чийдэн |   | 10 | Номын тавиур |
| 11 | Сурагчийн брайль самбар |   | 12 | Шивүүр |
| 13 | Брайль цаас |   | 14 | Брайль үсэг |
| 14 | Цаасгүйгээр бичиж, унших төхөөрөмж |   | 16 | Брайль бичгийн машин |
| 17 | Дэлгэц уншигч |    | 18 | Оптикийн тэмдэгт таних |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 19 | Уншдаг сканнер |   | 20 | Уншигч машин |
| 21 | Брайль үсгээр хэвлэгч |  | 22 | Хуурцаг |
| 23 | Брайль тэмдэглэлийн дэвтэр |   | 24 | Брайль дэлхийн газрын зураг |
| 25 | Milestone 312 Дэйзи /DAISY/ тоглуулагч |    | 26 | Booksense DS S50 Дэйзи тоглуулагч |
| 27 | Өнгө мэдрэгч |   | 28 | Гэрэл мэдрэгч |
| 29 | Ярьдаг тооны машин |   | 30 | Цагаан таяг / |

2.3. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэмжих төхөөрөмж, хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн

1. Эвлүүлдэг, угсардаг тоглоомууд
2. Дохионы хэлний зурагт үзүүлэн
3. Дохионы хэлний зурагт толь бичиг
4. Дохионы хэлний цагаан толгой, 1-100 хүртэлх тооны зурагт хуудас
5. Дохионы хэлний зурган карт
6. 1000 үгтэй дохионы хэлний дүрст толь бичиг
7. Сонсголгүй хүүхэдтэй ажиллаж буй багш, эцэг эхчүүдэд зориулсан DVD хичээл
8. Мэдээллийн самбар
9. Дуу өсгөгч төхөөрөмж
10. Дуу дамжуулагч
11. Дуу өсгөгч аппарат
12. Дуу хүлээн авагчтай микрофон
13. Анивчдаг гэрэлт хонх
14. Сонсголын алдагдалтай хүмүүст зориулсан таблет
15. Видео утас

16. Сонсголын аппарат

| № | Нэр | Зураг | № | Нэр |
|---|---|---|---|---|
| **1** | Эвлүүлдэг, угсардаг тоглоомууд |   | **2** | Дохионы хэлний зурагт үзүүлэн |
| 3 | Дохионы хэлний зурагт толь бичиг |   | 4 | Дохионы хэлний цагаан толгой, 1-100 хүртэлх тооны зурагт хуудас |
| 5 | Дохионы хэлний зурган карт |   | 6 | 1000 үгтэй дохионы хэлний дүрст толь бичиг |
| 7 | Сонсголгүй хүүхэдтэй ажиллаж буй багш, эцэг эхчүүдэд зориулсан DVD хичээл |   | 8 | Мэдээллийн самбар |
| 9 | Дуу өсгөгч төхөөрөмж |   | 10 | Дуу дамжуулагч |
| 11 | Дуу өсгөгч аппарат |   | 12 | Дуу хүлээн авагчтай микрофон |
| 13 | Анивчдаг гэрэлт хонх |   | 14 | Сонсголын алдагдалтай хүмүүст зориулсан таблет |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Видео утас |   | 16 | Сонсголын аппарат |

2.4. Харилцааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, орлуулах болон сайжруулах хэрэгсэл, тохируулгат сургалтын хэрэглэгдэхүүн

1. Хөгжимт, дуут тоглоом, зурагт номууд
2. Ярьдаг зургийн цомог
3. Өгүүлэх эрхтэнтэй танилцах тоглоом
4. Авиан зөв дуудлагыг хөгжүүлэх цуврал ном
5. Хэл заслын дасгал, даалгаврууд цуврал ном
6. Үлээдэг лото
7. Цагийн хуваарийн үзүүлэн
8. Зураг солилцох тоглоом
9. Тэмдэгтээр харилцан ярилцах тоглоом
10. Ярьдаг толь
11. Хуванцар, акустик хоолой DUET
12. Тольтой ширээ

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөгжимт, дуут тоглоом, зурагт номууд |   | 2 | Ярьдаг зургийн цомог | |
| 3 | Өгүүлэх эрхтэнтэй танилцах тоглоом |    | 4 | Авиан зөв дуудлагыг хөгжүүлэх цуврал ном | |
| 5 | Хэл заслын дасгал, даалгаврууд цуврал ном |   | 6 | Үлээдэг лото | |
| 7 | Цагийн хуваарийн үзүүлэн |   м | 8 | Зураг солилцох тоглоом | |
| 9 | Тэмдэгтээр харилцан ярилцах тоглоом |   | 10 | Ярьдаг толь | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | Хуванцар акустик хоолой |    | 12 | Тольтой ширээ | |

2.5. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэмжих төхөөрөмж, хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн

1. Булчин хөгжүүлдэг тоглоомууд
2. Бөмбөгний нүхтэй самбар /шийд/
3. Алхалтын шат
4. Савлуур
5. Уян тууз
6. Мэдрэгчтэй хавтан
7. Харандаа, үзэг бэхлэгч
8. Хурууны багс
9. Үзэг, харандааг барихад туслах хэрэгсэл
10. Зөөлөн сандал
11. Эмчилгээний зориулалттай бөмбөгтэй сандал
12. Дээд мөчний хөгжлийг дэмжих төхөөрөмж
13. Алхагч, хөлд оруулагч
14. Массажны сандал RestArt RK-2686
15. Тэнцвэржүүлэгч мастер төхөөрөмж
16. Компьютерийн техник хэрэгслийн багц
17. Компьютерийн тусгай хэрэгслүүд

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Булчин хөгжүүлдэг тоглоомууд |   | **2** | Бөмбөгний нүхтэй самбар | |
| 3 | Алхалтын шат, хана |   | 4 | Савлуур | |
| 5 | Уян тууз |   | 6 | Мэдрэгчтэй хавтан | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Харандаа, үзэг бэхлэгч |   |  | 8 | Хурууны багс | |
| 9 | Үзэг, харандаа барихад туслах хэрэгсэл |  |  | 10 | Зөөлөн сандал | |
| 11 | Эмчилгээний зориулалттай бөмбөгтэй сандал |  |  | 12 | Дээд мөчний хөгжлийг дэмжих төхөөрөмж | |
| 13 | Алхагч, хөлд оруулагч |  |  | 14 | Массажны сандал | |
| 15 | Тэнцвэржүүлэгч мастер төхөөрөмж |  |  | 16 | Компьютерийн техник хэрэгслийн багц | |
| 17 | Компьютерийн тусгай хэрэгслүүд |     | | | | |

## Хавсралт 3. Хичээлийн жишиг хэрэглэгдэхүүн

### 3.1. Математикийн хичээлийн жишиг хэрэглэгдэхүүн

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1-10 хүртэл тоо тоолол |  | 8 | Тоо тооллын савхан сет |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Тоо тоолол /заан/ |  | 9 | Тоо тоолол /пирамид/ |  |
| 3 | Үржих үйлдлийн карт |  | 10 | Соронзтой гар самбар |  |
| 4 | IQ Puzzle |  | 11 | Том жижгийг ялгах карт |  |
| 5 | Шингэн хэмжигч багц |  | 12 | Мэдрэхүйн сургалтын куб |  |
| 6 | Тооны жинлүүр |  | 13 | Тоо тооллын самбар |  |
| 7 | 1-10 тооны бүтэц |  | 14 | Кума шоо |  |
| 15 | Шүдний загвар |  | 22 | Өнгийн карт |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Хэмжигдэх үүний цилиндр |  | 23 | Дүрсний хавтан |  |
| 17 | Тоо тоолол |  | 24 | Сампин |  |
| 18 | Тоо тооллын хичээлийн багц |  | 25 | Оньсон тоглоом |  |
| 19 | Тоо тооллын тоглоом |  | 26 | Өнгөт дүрсийг шигтгэн эвлүүлэх |  |
| 20 | Оюун ухааны puzzle |  | 27 | Тоо тооллын анхан шатны багц |  |
| 21 | Дүрст хайрцаг |  | 34 | Өнгө дүрс ялгах тоглоом |  |

### 3.2. Монгол хэлний хичээлийн жишиг хэрэглэгдэхүүн

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нүүрний хувирал олох тоглоом |  | 12 | Нэрлэх карт /амьтан/ |  |
| 2 | Ангилан ялгах тоглоом |  | 13 | Нэрлэх карт /өнгө/ |  |
| 3 | Зургийг гүйцээх домино |  | 14 | Зурган карт /хоол хүнс/ |  |
| 4 | “Эрүүл хүнс” карт |  | 15 | Дүрс болон өнгөний карт |  |
| 5 | Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх тоглоом |  | 16 | Эсрэг утга илэрхийлэх тоглоом |  |
| 6 | Амьсгалын дасгал /зурган карт/ |  | 17 | Ангилах хайрцаг /амьтан/ |  |
| 17 | Амьтан хайх фазл |  | 25 | Нүүрний хувирал эвлүүлэх тоглоом |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | Холбоотой зүйлийг ол |  | 26 | Өдөр тутмын амьдрал болон дүгнэлт хийх |  |
| 19 | Илүүг ол |  | 27 | Akros муу зуршил засах |  |
| 20 | Дугуй зам тоглоом |  | 28 | Байршил зүг чигийн карт |  |
| 21 | Ажил мэргэжлийн карт |  | 29 | Akros амьтны зурган карт |  |
| 22 | Өдөр тутмын амьдрал болон мэдрэмжүүд |  | 30 | Akros эсрэг утга илэрхийлэх зурган карт |  |
| 23 | Akros зөв үйлийг хайх |  | 31 | Нүүрний хувирал илэрхийлэх тоглоом |  |
| 24 | Нүүрний хувирал илэрхийлэх тоглоом |  | 32 | Буруу картыг ол |  |

### 3.3. Хөгжмийн хичээлийн жишиг хэрэглэгдэхүүн

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөгжмийн сэт |  | 9 | Чихрэн бөмбөр |  |
| 2 | 4 инчийн арьсан Шагшуурга |  | 10 | Цохиур хөгжим |  |
| 3 | 6 инч гурвалжин хөгжим |  | 11 | Металь kazoo |  |
| 4 | Chime хөгжим |  | 12 | Ноотны карт |  |
| 5 | Чихрэн бөмбөр |  | 13 | Boom whacker хөгжим |  |
| 6 | Цохиур хөгжим |  | 14 | Vibra-slap |  |
| 7 | Рачет / 21 * 20 см |  | 15 | Pororo микрафон |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Цохиур хөгжим |  | 16 | Wood block |  |
| 17 | Модон хөгжмийн багц |  | 26 | Ноот ялгах дуут хонх |  |
| 18 | Цохиур хөгжим |  | 27 | Ноот ялгах дуут хонх бариултай |  |
| 19 | Металь kazoo |  | 28 | Шагшуурга |  |
| 20 | Ноотны карт |  | 29 | cabasa |  |
| 21 | Boom whacker Хөгжим |  | 30 | Ширээны Castanets |  |
| 22 | vibra-slap |  | 31 | Гар бөмбөр |  |
| 23 | Pororo микрофон |  | 32 | Rohema Багц хөгжим |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | Жижиг бөмбөр |  | 33 | Гар Castanets |  |
| 25 | Хөгжмийн сэт |  | 34 | Cowbell |  |

### 3.4. Биеийн тамирын хичээлийн жишиг хэрэглэгдэхүүн

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дугуйлангийн багц |  | 7 | Тэнцвэрийн тавцан |  |
| 2 | Хөл холбогч |  | 8 | Тэнцвэржүүл эгч |  |
| 3 | 4 зүгт шат |   | 9 | Бочи |  |
| 4 | Бөмбөг зөөгч |  | 10 | Соронзтой дартс |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Бөмбөг авагч |  | 11 | Хөл бөмбөгийн багц |  |
| 6 | Дээс |  | 12 | Туузны цуглуулга |  |
| 13 | Pedalo |  | 20 | Шүхэр |  |
| 14 | Солонгон скүтер |  | 21 | Цагираг |  |
| 15 | Зангуутай дартс |  | 22 | Ogo disk |  |
| 16 | Бөмбөрцөг алхах багц |  | 23 | Үсэрдэг бөмбөг |  |
| 17 | Онооны самбар |  | 24 | Bowling сет |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | Дүрс шидэгч |  | 25 | Тэвэг |  |
| 19 | Сагстай бөмбөг |  | 26 | Зангуут оноот самбар |  |

## 3.5. Мэдрэхүй хөгжүүлэх хичээлийн хэрэглэгдэхүүн

| № | Нэр | Зураг | № | Нэр | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүрэлцэх мэдрэхүйн тоглоом |  | 8 | Хүрэлцэх мэдрэхүй хөгжүүлэх өрдөг тоглоом |  |
| 2 | Материал ялгах тоглоом |  | 9 | Х/Мэдрэхүйн зураас 8сэт |  |
| 3 | Жин хэмжих цилиндр |  | 10 | х/мэдрэхүйн дүрст тоглоом |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Цоож |  | 11 | Мэдрэхүйн блок |  |
| 5 | Хайчны сэт |  | 12 | Мэдрэхүйн 8 төрлийн бээлий |  |
| 6 | Domino |  | 13 | Ахуйн дадал олгох тоглоом 1 |  |
| 7 | Мэдрэхүй хөгжүүлэх тоглоом |  | 14 | Ахуйн дадал олгох тоглоом 2 |  |

---ooOoo---